

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Төвшрүүлэх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

### Аудитын код: АРА-2026/128/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Архангай аймаг

2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Грунт финанс Аудит ХХК-ийн

Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж

Утас: 7772-1628

Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.24 № 42

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨВШРҮҮЛЭХ  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Б.ДАВААСҮРЭН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Төвшрүүлэх сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,096,700.2 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, төсвийн зардлын нийт гүйцэтгэлээр 1,075,412.7 мянган төгрөг зарцуулсан байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 үндсэн зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Данс код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>193,420,395.67</b>	<b>178,378,459.87</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	70,334,175.46	20,786,830.55
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	70,334,175.46	20,786,830.55
31211	Төрийн сангийн харилцах	70,334,175.46	20,786,830.55
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>123,086,220.21</b>	<b>157,591,629.32</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>8,813,187.00</b>	<b>8,813,187.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	8,355,187.00	8,355,187.00
35130	Эм боох материал	458,000.00	458,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>114,273,033.21</b>	<b>148,778,442.32</b>
35410	Бичиг хэргийн материал	2,170,800.00	2,624,300.00
35420	Аж ахуйн материал	103,068,633.51	129,614,212.62
35440	Түлш, шатах тослох материал	123,300.00	7,299,930.00
35450	Барилгын засварын материал	100,500.00	100,500.00
35460	Хүнсний материал	-	329,700.00
35470	Бусад хангамжийн материал	8,809,799.70	8,809,799.70
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>284,233,661.63</b>	<b>2,706,280,714.74</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	284,233,661.63	2,706,280,714.74
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	269,219,328.30	2,686,238,381.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	209,855,412.89	2,689,942,996.89
39202	Хуримтлагдсан элэгдэл	(77,646,649.89)	(117,799,549.47)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	92,046,230.00	92,490,230.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,783,651.21)	(53,489,174.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	91,515,740.27	107,019,809.19
39208	Хуримтлагдсан элэгдэл	(43,457,947.15)	(54,240,336.88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	118,438,901.00	118,438,901.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(87,949,411.18)	(98,325,197.98)
39217	Ном	2,200,703.57	2,200,703.57
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	15,014,333.33	20,042,333.33
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(291,666.67)	(291,666.67)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,006,000.00	20,034,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>477,654,057.30</b>	<b>2,884,659,174.61</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>800,000.00</b>	<b>5,372,245.49</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	800,000.00	5,372,245.49
<b>413</b>	<b>Өглөг</b>	800,000.00	5,372,245.49
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	800,000.00	5,372,245.49
41361	Байгууллагад төлөх өглөг	800,000.00	5,372,245.49
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>476,854,057.30</b>	<b>2,879,286,929.12</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	476,854,057.30	2,879,286,929.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	153,877,280.71	153,877,280.71
512	Хуримтлагдсан үр дүн	180,916,100.54	2,583,348,972.36
51210	Өмнөх үеийн үр дүн	180,916,100.54	180,916,100.54
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,402,432,871.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	142,060,676.05	142,060,676.05
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>477,654,057.30</b>	<b>2,884,659,174.61</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр)

дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>852,526,219.97</b>	<b>3,552,820,749.92</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>111,826,319.97</b>	<b>2,546,454,749.92</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	111,826,319.97	2,546,454,749.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	111,826,319.97	2,546,454,749.92
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	20,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	60,015,518.48	2,499,075,152.92
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	50,810,801.49	27,379,597.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>740,699,900.00</b>	<b>1,006,366,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	688,478,300.00	926,191,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	688,478,300.00	926,191,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	52,221,600.00	80,175,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,221,600.00	80,175,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>809,698,784.67</b>	<b>1,150,387,878.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>809,698,784.67</b>	<b>1,150,387,878.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	804,314,184.67	1,125,052,646.10
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	553,510,275.00	780,012,736.54
210101	Үндсэн цалин	373,143,754.00	490,949,303.00
210102	Нэмэгдэл	152,680,563.00	233,705,426.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	8,621,937.00
210104	Урамшуулал	27,685,958.00	46,736,070.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	70,607,566.77	98,992,984.96
210201	Тэтгэврийн даатгал	47,735,085.53	66,426,025.69
210202	Тэтгэмжийн даатгал	5,506,158.31	7,751,772.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,637,529.58	5,325,993.72
210204	Ажилгүйдлийн даатгал	2,705,258.03	3,867,677.14
210205	Эрүүл мэндийн даатгал	11,023,535.32	15,621,515.95
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	57,746,600.00	70,247,738.00
210301	Гэрэл, цахилгаан	10,032,577.00	15,158,558.00
210302	Түлш, халаалт	47,664,023.00	54,169,650.00
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	919,530.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	60,961,145.30	68,875,078.90
210502	Хоол, хүнс	60,961,145.30	68,875,078.90
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	2,250,000.00
210604	Урсгал засвар	-	2,250,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,282,700.00	172,984.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,282,700.00	172,984.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	60,205,897.60	104,501,123.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,384,639.60	25,113,543.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,016,500.00	370,980.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,804,758.00	79,016,599.81
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,384,600.00	25,335,232.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,384,600.00	24,834,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,384,600.00	24,834,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	500,632.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	500,632.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>42,827,435.30</b>	<b>2,402,432,871.82</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>42,827,435.30</b>	<b>2,402,432,871.82</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>741,699,900.00</b>	<b>1,026,366,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,000,000.00</b>	<b>20,000,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,000,000.00</b>	<b>20,000,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	20,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	20,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>740,699,900.00</b>	<b>1,006,366,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>688,478,300.00</b>	<b>926,191,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	688,478,300.00	926,191,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>52,221,600.00</b>	<b>80,175,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,221,600.00	80,175,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>771,814,537.17</b>	<b>1,073,924,844.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>771,814,537.17</b>	<b>1,073,924,844.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>766,429,937.17</b>	<b>1,048,589,612.91</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>553,510,275.00</b>	<b>780,012,736.54</b>
210101	Үндсэн цалин	373,143,754.00	490,949,303.00
210102	Нэмэгдэл	152,680,563.00	233,705,426.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	8,621,937.00
210104	Урамшуулал	27,685,958.00	46,736,070.00
<b>2102</b>	<b>Ажил олгогч нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>70,607,566.77</b>	<b>98,992,984.96</b>
210201	Тэтгэврийн даатгал	47,735,085.53	66,426,025.69
210202	Тэтгэмжийн даатгал	5,506,158.31	7,751,772.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,637,529.58	5,325,993.72
210204	Ажилгүйдлийн даатгал	2,705,258.03	3,867,677.14
210205	Эрүүл мэндийн даатгал	11,023,535.32	15,621,515.95
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>52,221,600.00</b>	<b>77,424,368.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,032,577.00	15,158,558.00
210302	Түлш, халаалт	42,139,023.00	61,346,280.00
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	919,530.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>61,726,595.80</b>	<b>66,836,153.41</b>
210502	Хоол, хүнс	61,726,595.80	66,836,153.41
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>2,250,000.00</b>
210604	Урсгал засвар	-	2,250,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,781,700.00</b>	<b>2,842,484.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,781,700.00	2,842,484.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>26,582,199.60</b>	<b>20,230,886.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,197,599.60	15,451,086.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,384,600.00	4,779,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,384,600.00</b>	<b>25,335,232.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,384,600.00</b>	<b>24,834,600.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,384,600.00	24,834,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>500,632.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	500,632.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(30,114,637.17)</b>	<b>(47,558,844.91)</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,145,000.00</b>	<b>1,988,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,145,000.00</b>	<b>1,988,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,145,000.00</b>	<b>1,988,500.00</b>
222001	Тоног төхөөрөмж	685,000.00	-
223001	Бусад хөрөнгө	1,460,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,988,500.00

Архангай аймгийн Төвшрүүлэх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(2,145,000.00)</b>	<b>(1,988,500.00)</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(32,259,637.17)</b>	<b>(49,547,344.91)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	102,593,812.63	70,334,175.46
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	70,334,175.46	20,786,830.55

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>153,877,280.71</b>	<b>142,060,676.05</b>	<b>138,088,665.24</b>	<b>434,026,622.00</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>153,877,280.71</b>	<b>142,060,676.05</b>	<b>138,088,665.24</b>	<b>434,026,622.00</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	42,827,435.30	42,827,435.30
<b>2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>153,877,280.71</b>	<b>142,060,676.05</b>	<b>180,916,100.54</b>	<b>476,854,057.30</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>153,877,280.71</b>	<b>142,060,676.05</b>	<b>180,916,100.54</b>	<b>476,854,057.30</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	2,402,432,871.82	2,402,432,871.82
<b>2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>153,877,280.71</b>	<b>142,060,676.05</b>	<b>2,583,348,972.36</b>	<b>2,879,286,929.12</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр )

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,096,435,600.00	1,075,412,712.91	21,022,887.09	98.08
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,096,435,600.00	1,075,412,712.91	21,022,887.09	98.08
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,071,601,000.00	1,050,578,112.91	21,022,887.09	98.04
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	798,005,000.00	780,012,736.54	17,992,263.46	97.75
210101	Үндсэн цалин	515,490,200.00	490,949,303.00	24,540,897.00	95.24
210102	Нэмэгдэл	255,995,300.00	233,705,426.54	22,289,873.46	91.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	8,621,937.00	(8,621,937.00)	-
210104	Урамшуулал	26,519,500.00	46,736,070.00	(20,216,570.00)	176.23
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	99,049,800.00	98,992,984.96	56,815.04	99.94
210201	Тэтгэврийн даатгал	67,176,500.00	66,426,025.69	750,474.31	98.88
210202	Тэтгэмжийн даатгал	7,968,300.00	7,751,772.46	216,527.54	97.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,984,200.00	5,325,993.72	(1,341,793.72)	133.68
210204	Ажилгүйдлийн даатгал	3,984,200.00	3,867,677.14	116,522.86	97.08
210205	Эрүүл мэндийн даатгал	15,936,600.00	15,621,515.95	315,084.05	98.02
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	77,925,000.00	77,424,368.00	500,632.00	99.36
210301	Гэрэл, цахилгаан	17,225,000.00	15,158,558.00	2,066,442.00	88.00
210302	Түлш, халаалт	58,700,000.00	61,346,280.00	(2,646,280.00)	104.51
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	919,530.00	1,080,470.00	45.98
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	-	-	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	68,414,300.00	66,836,153.41	1,578,146.59	97.69
210502	Хоол, хүнс	68,414,300.00	66,836,153.41	1,578,146.59	97.69
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,250,000.00	2,250,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	2,250,000.00	2,250,000.00	-	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,842,500.00	2,842,484.00	16.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,842,500.00	2,842,484.00	16.00	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	23,114,400.00	22,219,386.00	895,014.00	96.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,250,600.00	17,355,586.00	895,014.00	95.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,863,800.00	4,863,800.00	-	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	24,834,600.00	24,834,600.00	-	100.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	24,834,600.00	24,834,600.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,834,600.00	24,834,600.00	-	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,096,435,600.00	1,025,865,368.00	70,570,232.00	93.56
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	930,513,400.00	926,191,000.00	4,322,400.00	99.54
131001	Улсын төсвөөс санхүүжих	930,513,400.00	926,191,000.00	4,322,400.00	99.54
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	80,175,000.00	79,674,368.00	500,632.00	99.38
132001	Орон нутгийн төсвөөс	80,175,000.00	79,674,368.00	500,632.00	99.38
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	85,747,200.00	20,000,000.00	65,747,200.00	23.32
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	20,000,000.00	-	100.00

Архангай аймгийн Төвшрүүлэх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	65,747,200.00	49,547,344.91	16,199,855.09	75.36
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	70,334,175.46	70,334,175.46	-	
61	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	4,586,975.46	20,786,830.55	(16,199,855.09)	-75.36
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	30	30	-	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	13	13	-	100.00
631	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	125	125	-	100.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	125	125	-	100.00
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>				
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15	15	-	100.00
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	1	1	-	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1		100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13	13	-	100.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>1</sup> илрээгүй тул залруулга хийгээгүй.

Аудитаар залруулаагүй нийт 7,156.1 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 7,156.1 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага өгсөн.

Аудитаар залруулагдаагүй 5 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 7,156.1 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 12,371.1 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

#### 3.1 Албан шаардлага

3.1.1. "Балансын урамшуулал олгох тухай" тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2025.09.03-ны өдрийн А/38 дугаар тушаалыг үндэслэн "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр "улирлын үр дүнгийн урамшуулал"-тай давхардуулан "балансын урамшуулал" 623.6 мянган төгрөгийг нягтланд олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3.1.2. Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулалд 4,834.6 мянган төгрөгийг 24 ажилтанд олгохдоо зөвхөн "Хувь хүний орлогын албан татвар" 10 хувь болох 483.5 мянган төгрөгийг суутгасан байх бөгөөд 1,160.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган авч, төсөвт төлөөгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1 "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна": 19.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3.1.3 Үндсэн хөрөнгийн шинж агуулсан 20 нэр бүхий хөрөнгийг бараа материалын дансанд ангилсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 -т 'Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр, дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3.1.4 Тайлант онд харилцагч байгууллагуудтай тухай бүр тооцоо нийлж, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүйгээс оны эцэст 5,372.2 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3.1.5 Эд хөрөнгийн жилийн эцсийн тооллого хийх 2025.12.12-ны өдрийн А/14 тушаал гаргаж тооллого хийсэн хэдий ч Бараа материалын тооллогыг үнэн зөвөөр хийгээгүй, тооллогын үлдэгдлийг 2025 оны 1 дүгээр сарын 31-ээр программаас татаж баримтжуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйл 72.4-т заасны дагуу "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх". 73 дугаар зүйл 73.2-т заасны дагуу "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" Төрийн өмчийн бодлого зохицуулалтыг газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтэг журам"-ын 3.1 дүгээр зүйл Өмч хамгаалах зөвлөл нь төрийн өмчийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, ашиглалтад хяналт тавих, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллана" гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Эд хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг хууль, журмын дагуу үнэн зөв зохион байгуулж, бодит үлдэгдэлд тулгуурлан анхан шатны баримтыг зөв огноо, хугацаагаар бүрдүүлж, тооллогын үр дүнг комиссын хурлаар хэлэлцэн баталгаажуулж, илэрсэн зөрчлийг хуульд заасан хугацаанд нягтлан бодох бүртгэлд тусган дансны үлдэгдлийг тулган шалгаж, Өмч хамгаалах зөвлөлийн хяналтыг сайжруулан цаашид зөрчил давтагдахгүй байх дотоод хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Балансын урамшуулал олгосон	1	623.6			1	1,897.0		
НДШ суутган буюу ногдуулаагүй	1	1,160.3			1	2,039.3		
Хөрөнгийн ангилал буруу	1	-			1	-		
Өр төлбөрийн данстай холбоотой	1	5,372.2			1	5,372.2		
Эд хөрөнгийн Тооллоготой холбоотой	1	-			1	-		
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>7,156.1</b>	-	-	<b>5</b>	<b>7,156.1</b>	-	-